



## НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

### “Стратегийн команд штабын сургуулийг” зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн “Стратегийн команд штабын дадлага сургууль зохион байгуулах тухай” А/194 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл хангуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сургуулийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Стратегийн команд штабын сургуулийг өндөр түвшинд зохион байгуулахыг дүүргийн Засаг даргын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа), Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-т, бэлэн байдлыг хангаж, идэвхи санаачлагатай оролцохыг дүүргийн нутгийн захиргааны нийт байгууллагын удирдлага, албан хаагчдад тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2023 он ажил захирамж

1123000165

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 03 сарын 17-ны өдрийн А.Б. дугаар  
Захирамжийн нэгдүгээр хавсралт



Нэг. Гамшгаас хамгаалах команд штабын дадлага, сургуулийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах ерөнхий ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:

- Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн суудал хариуцсан орлогч

Ажлын хэсгийн орлогч:

- Онцгой байдлын хэлтсийн дарга

Гишүүд:

- Засаг даргын зөвлөх
- Засаг даргын Тамгын газрын дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Боловсролын хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Газар зохион байгуулалтын албаны дарга
- "Илч-орд" ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга
- "Налайх" эрчим хүчний Багахангай хэсгийн мастер
- Мал эмнэлгийн тасгийн дарга
- УБТЗ-ын "Багахангай" өртөөний дарга,
- Нэгдүгээр хорооны Засаг дарга
- Хоёрдугаар хорооны Засаг дарга

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн орлогч
- Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн

Хоёр. Дүүргийн Гамшгаас хамгаалах болон Газар хөдлөлтийн үед ажиллах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Нэгдүгээр хорооны Засаг дарга
- Хоёрдугаар хорооны Засаг дарга
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нар

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн орлогч
- Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Гурав. Нүүн шилжих дадлага сургуулийг зохион байгуулах дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч

Гишүүд:

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга
- Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Боловсролын хэлтсийн дарга
- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Цагдаагийн хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Газар зохион байгуулалтын албаны дарга
- "Илч-орд" ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга
- "Налайх" эрчим хүчний Багахангай хэсгийн мастер
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Нэгдүгээр хорооны Засаг дарга
- Хоёрдугаар хорооны Засаг дарга
- Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн захирагч

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн орлогч
- Онцгой байдлын хэлтсийн ГТУХ-ын байцаагч

Дөрөв. Команд штабын дадлага сургуулийг зохион байгуулах сургуулийн үеийн албан хэрэг хөтлөлт, архивын дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа өргөдөл, гомдол хариуцсан Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

- Архив, албан хэрэг хөтлөлт, түүний зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Албан хэрэг, хөтлөлт хариуцсан ажилтан
- Гамшгаас хамгаалах албадын дарга нар

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн бичиг хэрэг, архивын эрхлэгч

Тав. Санхүү, хангалт хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

- Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Засаг даргын тамгын газрын ерөнхий нягтлан бодогч
- Байгууллагуудын Гамшгаас хамгаалах албадын санхүү хариуцсан албан тушаалтан

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн ахлах нягтлан бодогч

Зургаа. Даргын ажлын болон шийдвэрийн зураг хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга

Гишүүд:

- Газар зохион байгуулалтын албаны дарга
- Онцгой байдлын хэлтсийн орлогч
- Гал түймр унтраах, аврах 80 дугаар ангийн захирагч

Нарийн бичиг:

- Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн салааны захирагч

Долоо. Холбоо зарлан мэдээлэл, сургалт сурталчилгаа, хэвлэл мэдээлэл хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

- Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн
- Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
- Онцгой байдлын хэлтсийн дуудлага хүлээн авагч нар

Нарийн бичиг:

- Мэдээ мэдээлэл хариуцсан ажилтан

Найм. Дэд бүтэц, барилга байгууламжийн судалгаа хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч:

- Засаг даргын зөвлөх

Гишүүд:

- Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- “Илч-Орд” ОНӨААТҮГ-ын захирал
- “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-ын захирал
- “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал
- Ус суваг ашиглалтын товчооны дарга
- “Налайх” эрчим хүчний Багахангай хэсгийн мастер

Нарийн бичиг:

- Дэд бүтэц, тохижилт, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын-  
2023 оны 03 сарын 14-ны өдрийн А.С. дугаар  
Захирамжийн хоёрдугаар хавсралт

ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СТРАТЕГИЙН  
КОМАНД-ШТАБЫН СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран дэмжлэг үзүүлэх байгууллага, албан тушаалтан	Хугацаа
Нэг. Удирдлага зохион байгуулалт				
1	Сургууль зохион байгуулахад оролцох мэргэжлийн байгууллагын албан хаагчдыг томилгоожуулж, үүрэг, чиглэл өгч, бэлтгэл ажлыг хангах	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа А.Дашням	03 дугаар сард
2	Стратегийн команд-штабын сургууль зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж шийдвэрлүүлэх	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Мягмарсүрэн	Санхүү, хангалт хариуцсан ажлын хэсэг	03 дугаар сард
3	Дүүргийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, газар хөдлөлтийн үед ажиллах төлөвлөгөөг тус тус тодотгож, шинэчлэн боловсруулах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн гамшгаас хамгаалах болон газар хөдлөлтийн гамшгийн үеийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг	03, 04 дүгээр сард
Хоёр. Сургалт, дадлага, сургууль				
4	Дүүргийн Онцгой комиссын гишүүд, удирдах бүрэлдэхүүнд "Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт" сэдэвт сургалт зохион байгуулах	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа, Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	ОБЕГ-ын дэд дарга, сургуулийн удирдагч, бригадын генерал Б.Ууганбаяр	03 дугаар сард
5	Дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, холбогдох мэргэжлийн байгууллагуудад "Газар хөдлөлтийн гамшгийн үеийн удирдлага, зохион байгуулалт" сэдэвт сургалт зохион байгуулах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	03, 04 дүгээр сард

6	Дүүргийн нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид "Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах" чиглэлээр сургалт зохион байгуулах	Дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Хорооны Засаг дарга нар	Дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Л.Санжийжамц	03, 04, 05 дугаар сард
7	Багахангай дүүргийн Эрчим хүчний "Өндөр толгой" салбар /Цахилгаанаар хангах алба/-нд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах.	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Багахангай дүүргийн Эрчим хүчний "Өндөр толгой" салбарын хэсгийн мастер С.Алтанхүү	04 дүгээр сард
8	Нийслэлийн Засаг даргын захирамжаар Түр орон байраар томилгоожсон сургууль, спорт хорооны ажилтан алба хаагчдад гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга, Б.Цогжавхлан, Боловсролын хэлтсийн дарга, Ш.Баасансүрэн	03, 04, 05 дугаар сард
9	Газар хөдлөлтийн аюулын үед дүүргийн иргэдийг зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, аюулгүй талбайд цугларах сургалт, дадлагыг зохион байгуулах	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	05 дугаар сард
Гурав. Бэлтгэл ажлыг хангах талаар				
10	Нүүн шилжих дадлага сургуулийн бэлтгэл ажлыг хангуулах	Онцгой комиссын гишүүд, холбогдох мэргэжлийн байгууллагууд	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	04, 05 дугаар сард
11	Сургуулийн үеийн суурин болон хөдөлгөөнт удирдлагын байрыг бэлтгэн бүрэлдэхүүнийг томилгоожуулан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгөх	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа, Засаг даргын тамгын газрын дарга Л.Санжийжамц	04, 05 дугаар сард
12	Даргын ажлын болон шийдвэрийн зургийг бэлтгэн, тактикийн таних тэмдэг, тэмдэглэгээ, холбогдох тооцоо өгөгдлийг зурагт оруулах	Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Б.Батмөнх	Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	04, 05 дугаар сард
13	Дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгож, хүч хэрэгслийн нарийвчилсан судалгаа гаргах	Дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нар	Онцгой байдлын хэлтсийн орлогч, дэд хурандаа Г.Ганзориг	03, 04 дүгээр сард
14	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 94 дүгээр, 2020 оны 17 дугаар тогтоолоор баталгаажсан	Газар зохион байгуулалтын албаны дарга Ч.Магадсайхан	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	04, 05 дугаар сард

	Болзошгүй гамшгийн үед түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх байршлыг зурагт оруулж, бүртгэлийн хуудас бэлтгэх			
15	Сургуулийн үеийн албан хэрэг хөтлөлтийн бэлтгэл ажлыг ханган, баримт бичгийг материалжуулан архивлах.	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гэрэлцолмон	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	05 дугаар сард
16	Дүүргийн гамшгаас хамгаалах албадад Команд штабын сургуулийн Шуурхай штабыг байгуулан, ажиллах бүрэлдэхүүнийг томилж, бичгийн болон техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах	Дүүргийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн дарга нар	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа, Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Б.Цогбадрах	05 дугаар сард
Дөрөв. Сурталчилгаа, мэдээллийн талаар				
17	Түр цугларах талбайд иргэдийг бүртгэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Уранцэцэг	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	05 дугаар сард
18	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах зар сурталчилгааны самбар, бүх төрлийн цахим мэдээллийн хэрэгслээр сургуулийн зорилго, онцлог, ач холбогдлын талаарх мэдээллийг тухай бүр иргэд олон нийтэд түгээх	Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Отгонжаргал	Дүүргийн Засаг даргын орлогч, Б.Болормаа	04, 05 дугаар сард